

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын
2020 оны 100 тоот тушаалын 7 дугаар хавсралт

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ АРГА, ХЭМЖЭЭ							
“Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр” Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлж, хүн амын бүлгүүдийн хөгжил, оролцоог хангах, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, нийгмийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн салбар дундын гэр бүлд ээлтэй цогц бодлого боловсруулж, хүн амын тогтвортой өсөлт, гэр бүл, хүний хөгжлийг дэмжих стратегийн зорилт 2.4.3.							
1	Зорилт 2: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангах, оролцоо, хүртээмжийг сайжруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох	Улсын төсөв	Хуулийн төсөл /тоо/ Өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /тоо/ ЗГ-ын хуралдааны хэлэлцүүлэг /тоо/	0 0 0	3 2 2	Хуулийн төслийн холбогдох баримт бичгийн төсөл болох зардлын тооцоо, хэрэгцээ шаардлагын тандалт судалгааг боловсруулсан бөгөөд дагалдан гарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд 3 хуулийн төсөл боловсруулах ажлын явц дунджаар 60 хувьтай байна.	90
1.1	Арга хэмжээ 2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон, дагалдан нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. / АХ-2050 - 2.3.3, ЗГҮАХ 2024-2028 -2.1.1.23/	Улсын төсөв	Хуулийн төсөл /тоо/ Дагалдан гарах хуулийн төсөл /тоо/ Засгийн газрын хуралдааны тэмдэглэл /тоо/	0 0 0	1 20 1	ГБХНХ-ын сайдын 2025 оны А/22 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсгийн хурлыг тайлант хугацаанд 3 удаа зохион байгуулж, хуулийн төслийн холбогдох баримт бичгийн төсөл болох зардлын тооцоо, хэрэгцээ шаардлагын	90

						тандалт судалгааг боловсруулсан бөгөөд дагалдан гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд хуулийн төсөл боловсруулах ажлын явц 70 хувьтай байна.	
1.2	Арга хэмжээ 2.2. Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн болон түүнийг нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. /АХ-2050 2.3.3, ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.24/	Улсын төсөв	Хуулийн төсөл /тоо/	0	1	ГБХНХ-ын сайдын 2025 оны А/22 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсгийн хурлыг тайлант хугацаанд 2 удаа зохион байгуулж, хуулийн төслийн холбогдох баримт бичгийн төсөл болох зардлын тооцоо, хэрэгцээ шаардлагын тандалт судалгааг боловсруулсан бөгөөд дагалдан гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд хуулийн төсөл боловсруулах ажлын явц 60 хувьтай байна.	90
			Дагалдан гарах хуулийн төсөл /тоо/	0	20		
			Засгийн газрын хуралдааны тэмдэглэл /тоо/	0	1		
1.3	Арга хэмжээ 2.3. Дохионы хэлний тухай хуулийн төсөл боловсруулна.	Улсын төсөв	Хуулийн төсөл /тоо/	0	1	ГБХНХ-ын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/22 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар Дохионы хэлний тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсгийн хурлыг тайлант хугацаанд 2 удаа зохион байгуулж, хуулийн төслийг хуралд оролцогчдын саналыг тусган хянан сайжруулж байна. Мөн ажлын хэсэг "Монгол дохионы хэл ба хөгжлийн чиг хандлага" хэлэлцүүлгийг 2025 оны 03 дугаар 28-ны өдөр Боловсролын яам болон харьяа байгууллагууд,	90
			Үзэл баримтлалын төсөл /тоо/	0	1		

						СЗСҮТ, МБУЧОС, МУСИҮХ, Сонсголгүйн боловсрол, Тэгш тусгал ТББ-дын төлөөлөл, Олон улсын хөгжлийн болон донор байгууллагын төлөөлөлтэй хамтран зохион байгуулсан. Мөн “Сонсголгүйн боловсрол” ТББ, Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоотой хамтран “Эрт үеийн оролцоо ба сонсголгүйн боловсрол” хэлэлцүүлгийг 06 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж, хуулийн төслийг хэлэлцүүлсэн. Хуулийн төсөл боловсруулах ажлын явц 60 хувьтай байна.	
2. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
2.1	Зорилт 4: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил бодлогын удирдамжаар хангах;		Хэрэгжүүлсэн арга хэмжээ /тоо/	10	25	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн үйлчилгээний зураглалыг төрийн бус байгууллагуудтай хамтран боловсруулж, Эрүүл мэндийн яам, Боловсролын яамны холбогдох төлөөлөлд танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг үе шаттай нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх, салбар дундын хамтарсан ажлын хэсэг байгуулан, төлөвлөгөөг ЭМЯ, БЯ-тай хамтран гаргахаар ажлын хэсгийн удирдамжийг боловсруулан ажиллаж байна. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж, төрийн болон	90

						төрийн бус байгууллага, салбар комиссын гишүүдэд 2 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, дүрмийн төсөлд ирүүлсэн саналыг нэгтгэн ажиллаж байна.	
2.2	Арга хэмжээ 4.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээний боловсруулна. зураглалыг	үйл ажиллагааны зардал	Зураглал /тоо/	0	1	Хүүхдийг эхийн хэвлийд бүрэлдэхээс эхлээд хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, үнэлэх, нийгмийн оролцоог хангахад чиглэсэн тогтолцоог оновчтой бүрдүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжид тусгаж, амьдралын туршид нь нийгмийн хамгааллын нийцсэн үйлчилгээ үзүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн үйлчилгээний зураглалыг төрийн бус байгууллагуудтай хамтран боловсруулсан. Үйлчилгээний зураглалын төслийг Эрүүл мэндийн яам, Боловсролын яамны холбогдох төлөөлөлд танилцуулсан. Үйлчилгээний зураглалыг Эрүүл мэнд, Боловсрол, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан уулзалтад танилцуулахаар ажиллаж байна.	90
2.3	Арга хэмжээ 4.2. Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг туршина. /ЗГҮАХ 2024-2028 -2.1.1.25/	Улсын төсөв 50	Туршилт хийх аймаг, дүүрэг /тоо/	0	4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг зохион байгуулахаар ажлын хэсэг ажиллаж байгаа бөгөөд тус судалгааны асуулгад тус аргачлалыг ашиглахаар бэлтгэж байна. Мөн ХБИХЭДТ-д үйлчилгээ авах иргэдийн үнэлгээнд аргачлалыг ашиглахаар туршилтыг хийж эхлээд байна.	90

						Мөн Үйл ажиллагааны олон улсын ангилал (ICF)-ыг ашиглаж буй салбаруудын өнөөгийн байдал, цаашдын хамтын ажиллагааны талаарх салбар дундын уулзалт, хэлэлцүүлгийг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан. Уулзалтын үр дүнд хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг үе шаттай нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх, салбар дундын хамтарсан ажлын хэсэг байгуулан, төлөвлөгөөг ЭМЯ, БЯ-тай хамтран гаргахаар ажлын хэсгийн удирдамжийг боловсруулан ажиллаж байна.	
2.4	Арга хэмжээ 4.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг зарим аймаг, дүүрэгт байгуулна. /ЗГҮАХ 2024-2028 -2.1.1.26/	Улсын төсөв 6.000.0	Хөгжлийн төвтэй болсон аймаг, дүүрэг /тоо/	6	8	АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Баянзүрх дүүрэг, Завхан аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барьж, 2026 оны 09 дүгээр сард ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. Завхан аймагт баригдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 04 дүгээр сард зарлан 7 байгууллага материал ирүүлж, шалгараагүй тул 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр дахин зарласан бөгөөд 06 дугаар сарын 12-ны өдөр нээж, үнэлгээг хийнэ. Баянзүрх дүүрэгт баригдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн	Хугацаа болоогүй. Үнэлэх боломжгүй

						барилгын зураг төсөвт магадлал хийлгэхээр Барилгын хөгжлийн төвд хянуулахаар хүргүүлсэн. Өмнөговь аймагт орон нутгийн төсвөөр барьсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг ХБХХЕГ-ын харьяанд шилжүүлэх саналыг боловсруулан Засгийн газрын 2025 оны 212 дугаар тогтоолоор батлуулсан.	
2.5	Арга хэмжээ 4.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтын хүрээнд өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 4 хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах хуулийн хэрэгжилтийг хангуулна. /ЗГҮАХ 2024-2028 -2.1.1.27/	Улсын төсөв	Хөдөлмөрийн тухай хууль сахин мөрдөлтийн хувь	30%	86%	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтэд тус хэлтсээс дүн шинжилгээг хийсэн бөгөөд уг дүн шинжилгээнд татвар төлөгч топ 100 аж ахуйн нэгж, төрийн захиргааны төв байгууллагууд болон тус яамны харьяа байгууллагууд, мөн нийгмийн даатгалын мэдээллийн сан дахь аж ахуйн нэгж байгууллагуудын мэдээлэл, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн хөрөнгө зэрэгт харьцуулсан дүн шинжилгээг хийсэн. Уг дүн шинжилгээг ГБХНХ-ын сайдын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай 2025 оны 01 дүгээр сард хийсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн уулзалтад танилцуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн хүрээнд Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөн туслах улсын үзлэгийг	90

						бүх аймаг, дүүргийн 25 ба түүнээс дээш ажиллагчтай аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулан зохион байгуулах тухай Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/102 дугаар тушаалыг батлуулсан. 2025 онд 1000 гаруй аж ахуйн нэгж, байгууллагад улсын үзлэг хийнэ.	
2.6	Арга хэмжээ 4.6. Төр, хувийн хэвшил, нийгмийн түншлэлийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамж, үйлчилгээний чанарыг сайжруулна. /ЗГҮАХ 2024-2028 -2.1.1.29/	Улсын төсөв	Хувийн туслах, зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан иргэний тоо		400	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв нь хувийн туслахын үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын сонгон шалгаруулалтыг зарлаж нийт 9 байгууллага шалгарч гэрээг 2025 оны 05 сарын 29-ний өдөр байгуулсан. Тус сонгон шалгаруулалтын дагуу 2025 онд 50 иргэн хувийн туслахын үйлчилгээ авах боломж бүрдсэн.	70
2.7	Арга хэмжээ 4.7. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төвийг төв, орон нутагт ажиллуулна.	Улсын төсөв	Үйл ажиллагаа явуулах төв /тоо/	4	10	Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төвийг улсын хэмжээнд санхүүжүүлэн ажиллуулахад 2025 оны улсын төсөвт 8,9 тэрбум төгрөгийг тусгасан. Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/85, А/55, А/49 хамтарсан тушаалаар "Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн дүрэм"-ийг баталсан. Үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг Хөгжлийн бэрхшээлтэй	100

	Дэд арга хэмжээ 4.7.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих өдрийн үйлчилгээний (Дэмжих төв) аргачлал, заавар, үйлчилгээний үнэ тариф"-ыг боловсруулж, батлуулах	-	Сайдын тушаал /тоо/	0	1	хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран зохион байгуулж, Баянхонгор аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын хөгжлийн төв, Реха сентер, Энэрэлийн түүчээ, Энх гэр бүл, Эрхэм нандин сувд, Аутимэд хийсэн аялал, Ээлтэй Ертенц төрийн бус байгууллага гэсэн 7 байгууллага шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна.	
	Дэд арга хэмжээ 4.7.2. Үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах	Улсын төсөв	Үйл ажиллагаа явуулах төв /тоо/	4	10	Үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран зохион байгуулж, Баянхонгор аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын хөгжлийн төв, Реха сентер, Энэрэлийн түүчээ, Энх гэр бүл, Эрхэм нандин сувд, Аутимэд хийсэн аялал, Ээлтэй Ертенц төрийн бус байгууллага гэсэн 7 байгууллага шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна.	
2.8	Арга хэмжээ 4.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах эрх зүйн орчныг сайжруулах	-	Засгийн газрын тогтоол /тоо/	1	2	Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос гаргасан зөвлөмжийг 2025-2031 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг төрийн захиргааны төв байгууллагуудаас	80

						саналыг авч нэгтгэн ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд 99 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, Засгийн газрын 2025 оны 04 сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх цогц үйлчилгээний удирдамж болон комиссын дүрэмд ICF-ийг тусган чиглэлээр зөвлөх үйлчилгээний удирдамжийн төслийг боловсруулж байна.	
	Дэд арга хэмжээ 4.8.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын холбогдох дүрэм, журмыг шинэчилнэ.	-	Засгийн газрын тогтоол /тоо/;	0	1	Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллага, салбар комиссын гишүүдэд 2 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Ирүүлсэн саналыг дүрмийн төсөлд тусгаж байна. Энэ оны 4-6 дугаар сард зохион байгуулсан ХБХЭМБНХ-ын салбар комиссын сургалтын үеэр дүрмийн төслийг оролцогчдоор хэлэлцүүлж, санал авах ажлыг зохион байгуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх цогц үйлчилгээний удирдамж болон комиссын дүрэмд ICF-ийг тусган чиглэлээр зөвлөх үйлчилгээний удирдамжийн төслийг боловсруулж байна.	60

	Дэд арга хэмжээ 4.8.2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос гаргасан зөвлөмжийг 2025-2031 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;	-	Засгийн газрын тогтоол /тоо/	0	1	Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос гаргасан зөвлөмжийг 2025-2031 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг төрийн захиргааны төв байгууллагуудаас саналыг авч нэгтгэн ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд 99 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, Засгийн газрын 2025 оны 04 сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан.	100
3.1	Арга хэмжээ 7.1. Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх багц сургалтын хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллана: /ЗГҮАХ 2024-2028 -2.1.1.24/	Улсын төсөв 100	Төлөвлөгөө /тоо/	0	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан аяны хүрээнд 15 постер, контентийг олон нийтэд түгээж, хэвлэл мэдээллийн 12 байгууллагатай хамтран ажиллаж байна. Мөн хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, эерэг хандлагыг төлөвшүүлэх нөлөөллийн сургалтыг дараах байгууллага, албан хаагчдад зохион байгуулсан. Үүнд: - Нийслэлийн 9 дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн нийт 91 албан хаагчдад цахимаар; - Хан-Уул дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн 40 албан хаагчдад танхимаар; - Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн хэсгийн ахлагч нийт 44 хүнд танхимаар;	90
			Сургалт /тоо/	0	40		
			Контент /тоо/	0	100		

						ГБХНХ-ын Сайдын 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/82 дугаар тушаал, ХБХХЕГ-ын даргын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/46 дугаар тушаал, 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/73 дугаар тушаалын дагуу төвийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Хөвсгөл аймгийн ХБХХТ-ийн 29 албан хаагчдад, 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Дундговь аймгийн ХБХХТ-ийн 29 албан хаагчдад танхимаар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхжуулах сургалтыг тус тус зохион байгуулсан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн чиглэлээр олон улсын тэмдэглэлт өдрүүдийг угтаж хөгжлийн бэрхшээл өгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлснээр тухайн хүүхдэд хугацаа алдахгүйгээр хөгжлийн дэмжлэг үзүүлэх, мөн хоёрдогч хүндрэлээс сэргийлэх талаар постер, мэдээлэл бэлтгэн яамны пэйж хуудсанд байршуулж байна.	
3.2	Арга хэмжээ 7.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах эрхийг хангаж, мэдээллийн болон дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 2024-2028 -2.1.1.24/	Улсын төсөв 250		0	20	Дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд “Түгээмэл хөгжил” ТББ-тай хамтран ГБХНХЯ-ны барилгын гадна болон дотор орчны байдалд хүртээмжийн үнэлгээг хийсэн. Нийт 135 асуумжийн хүрээнд үнэлэхэд	Хугацаа болоогүй. Үнэлэх боломжгүй

			Үнэлгээний тоо		42.2% нь хүртээмжгүй үнэлэгдсэн байна. Иймд үнэлгээнээс гарсан тайлан, зөвлөмжийн дагуу сайжруулах арга хэмжээг төлөвлөж байна. Нийтийн тээврийн бодлогын газар, “Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо”-той хамтран 2025 оны 05 дугаар сард нийтийн тээврийн үйлчилгээнд явж байгаа зарим автобусны хүртээмжийн байдалд үнэлгээ хийсэн. Тус үнэлгээг “Нийтийн тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5012:2021, “Нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага UCS 1603B:2022 стандартыг баримтлан 15 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн. Үнэлгээнээс гарсан тайлан, санал зөвлөмжийг албан бичгээр Нийтийн тээврийн бодлогын газарт хүргүүлсэн. “Түгээмэл хөгжил” ТББ-тай хамтран “MONGOLIA TRY - 2025” нөлөөллийн арга хэмжээг 06 дугаар сарын 13-ний өдрөөс 24-нийг хүртэлх хугацаанд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Тус ажлын хүрээнд ТНБД-ийн “Нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах тухай” тушаалын төслийг батлуулсан ба удирдамж, хөдөө орон нутагт ажиллах төсвийн тооцоо болон хөтөлбөр, ажил гүйцэтгэх гэрээг тус тус гарган баталгаажууллаа. Мөн аймаг болон НЗДТГ-т хамтран	
--	--	--	-------------------	--	--	--

						ажиллах албан бичгийг хүргүүлээд байна. Мэдээллийн хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд “Зайнаас зөвлөн туслах төв”-ийн 1800-0724 тусгай дугаараар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэх, яам, салбарын үйл ажиллагааг сонсголын бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор дохионы хэлмэрч орчуулагч нартай гэрээ байгуулан ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар дохионы хэлмэрч орчуулагчид дараах үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнд: -Зайнаас зөвлөн туслах төвд хандсан нийт 1202 хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлсэн; -Шүүхийн шийдвэр болон цагдаагийн газраас ирүүлсэн албан бичгийн хүрээнд 8 удаагийн дохионы хэлмэрчийн үйлчилгээ үзүүлсэн; -1 контент; -14 удаагийн сургалт зөвлөгөөнд дохионы хэлмэрч орчуулагч; Дохионы хэлний анхан шатны сургалт 2 удаа зохион байгуулсан байна.	
3.3	Арга хэмжээ 7.3.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, олон улсын байгууллага, бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	адаадын зээл, тусламж	Хэрэгжилтийн хувь	80	80	Тайлант хугацаанд дараах олон улсын байгууллага, бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд: - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	100

						жилийн хүрээнд “Мянганы туурвил” ТББ; - Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөл, ГБХНХЯ-ны дэргэдэх дэд зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд зөвлөл, дэд зөвлөлийн бүрэлдэхүүн дэх төрийн бус байгууллагуудтай; - Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээний зураглалыг боловсруулах чиглэлээр Ээлтэй ертөнц, Аутизмд хийсэн аялал, Энэрэлийн түүчээ төрийн бус байгууллага, - дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах үнэлгээ хийх чиглэлээр Түгээмэл хөгжил төрийн бус байгууллага; - хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн эрт илрүүлэлтийн өдрийг угтан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулахад “Эрхэм нандин сувд” ТББ; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр Жайка олон улсын байгууллага; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагын судалгаа хийх зорилгоор АШУҮИС-тай тус тус хамтран ажилласан байна. Мөн Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн	
--	--	--	--	--	--	--	--

						хөгжлийг дэмжих нь төслийн хүрээнд Японы хүүхдийг ивээх сантай хамтран ажиллах санамж бичгийг байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг сайжруулахаар Баянхонгор, Сэлэнгэ аймаг, Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан зэрэг 3 дүүрэг, нийт 5 салбар комисстой хамтран ажиллаж байна. Юнескотой хамтран Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхжуулах сургалтыг хангайн болон төвийн бүсэд зохион байгуулахад хамтран ажиллаж байна.	
3.4	Арга хэмжээ 7.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулах, тайланг хянах;	Улсын төсөв	Хэрэгжилтийн хувь	67,2	90	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн хурлыг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр хамтран зохион байгуулж, тус хурлаар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 6 яамны дэд зөвлөлийн үйл ажиллагаанд хийсэн сонсголоос гарсан дүгнэлт, зөвлөмж, албан даалгавар танилцуулсан бөгөөд мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Үндэсний зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 19 арга хэмжээний хүрээнд үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна.	70

3.5	Арга хэмжээ 7.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангах, хагас бүтэн жилээр тайлагнах;	Улсын төсөв	Хэрэгжилтийн хувь	71	90	ГБХНХЯ-ны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн хурлыг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулж, тус хурлаар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Дэд зөвлөлөөс 2025 онд эрх зүйн орчинг боловсронгуй болгох хүрээнд 9 арга хэмжээ, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх төрийн үйлчилгээг сайжруулах хүрээнд 6 арга хэмжээ, нийт 15 арга хэмжээг харьяа агентлаг болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийн шатандаа байгаа 13 арга хэмжээ байна.	70
	Дэд арга хэмжээ 7.5.1. Салбарын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний жагсаалтыг батлан хэрэгжилтийг хангах;	-	Жагсаалт -1	0	1	ГБХНХСайдын “Үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв батлах тухай” 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/83 дугаар тушаалаар Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, хамгааллын чиглэлээр туссан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багц дахь “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээ” зардлын төсвийн хуваарийг баталсан. Уг тушаалын дагуу төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх 17 ажил, үйлчилгээний жагсаалтыг Төрийн нарийн бичгийн даргын	100

						тушаалаар батлуулсан. Тайлант хугацаанд 3 гэрээг байгуулж, 65 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.	
	Дэд арга хэмжээ 7.5.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэмдэглэлт өдрийн арга хэмжээг зохион байгуулах;	Улсын төсөв	Хэрэгжилтийн хувь	100	100	Тайлант хугацаанд 7 тэмдэглэлт өдрийг угтаж хөгжлийн бэрхшээл, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлснээр тухайн хүүхдэд хугацаа алдахгүйгээр хөгжлийн дэмжлэг үзүүлэх, мөн хоёрдогч хүндрэлээс сэргийлэх талаар постер, мэдээлэл бэлтгэн яамны пэйж хуудсанд байршуулсан байна. Мөн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн эрт илрүүлэлтийн өдрийг угтан “Эрхэм нандин сувд” ТББ-тай хамтран 21 аймгийн хөгжлийн бэрхшээлтэй 630 хүүхдийн эрт илрүүлгийг ЭХЭМҮТ-тэй хамтран зохион байгуулсан. Урьдчилан сэргийлэх үзлэгийн үр дүнд: 1. Тайлант хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй 378 хүүхдийг нарийн мэргэжлийн эмчийн хяналтад оруулж, эрт үед шаардлагатай эмчилгээ үйлчилгээнд хамруулсан. 2. Чиг гутал” ХХК-аас “Гоё мөрөө үлдээ” сайн үйлсийн аяны хүрээнд 100ш хөлийн чиг баригчийг үнэ төлбөргүй бэлэглэсэн. 3. ЭХЭМҮТөвийн болон АНУ-ын мэдрэлийн мэс заслын эмч нарын хамтарсан үзлэгт орон нутгийн 20 хүүхдийн хамруулж, цаашид хийгдэх эмчилгээний чиглэлийг өгсөн. 4. ГССҮТ дээр БНЭУ-ын мэдрэлийн мэс заслын эмч нарын	100

						хамтарсан үзлэгт шаардлагатай хүүхдүүдийг 6 дугаар сарын 10-ны өдөр хамруулсан.	
	Дэд арга хэмжээ 7.5.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн амьдралын чанарын судалгаа хийх;	Улсын төсөв	Судалгааны тоо	-	1	АШУҮИС-тай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлийн амьдралын чанар” сэдэвт судалгааны удирдамж, төсвийг боловсруулж, ТНБД-ын 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн “Удирдамж, төсөв батлах тухай” А/59 дүгээр тушаалаар батлуулсан. Мөн 03 дугаар сарын 26-ны өдрийн № 02/44 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулан холбогдох санхүүжилтийг шийдвэрлэсэн. Одоогийн байдлаар тус судалгаанд нийт хөгжлийн бэрхшээлтэй 264 хүүхэдтэй гэр бүлийг хамруулсан байна.	80
3.6	Арга хэмжээ 7.6.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангах	Улсын төсөв	Төлөвлөгөөний Хэрэгжилтийн хувь	-	90	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/48 тоот тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн төлөвлөгөө”-г 43 арга хэмжээтэй хэрэгжүүлэхээр баталсан. Төлөвлөгөөг харьяа агентлаг, газар хэлтсүүдэд хүргүүлж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнахаар ажиллаж байна. Мөн жилийн хүрээнд салбар дундын уялдааг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн, тэдний онцлог, хэрэгцээ, ур чадварт тохирсон хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг хүргэх, иргэд, ажил олгогчдын ойлголт, хандлагыг сайжруулах, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох	70

						хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/82 дугаар тушаалаар 6 бүсд зохион байгуулахаар баталсан. 2025 оны 06 дугаар сарын байдлаар Хөвсгөл, Дундговь аймгуудад бүсийн цогц арга хэмжээг хэрэгжүүлээд байна. Төлөвлөгөөний хэрэгжилт хагас жилийн байдлаар 70 хувьтай байна.	
3.7	Арга хэмжээ 7.7. Өмнөговь аймаг дахь төвийг харьяандаа шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн бүтэц, орон тоог шинэчлэн батлуулах	-	Засгийн газрын тогтоол	1	1	“Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 164 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулж, төрийн захиргааны төв байгууллагуудаас санал авч, Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 212 дугаар тогтоолоор “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолыг батлуулсан.	100
			Сайдын тушаал	1	1	“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2025 оны 212 дугаар тогтоолд нийцүүлэн Орон нутаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн дүрэм, бүтэц, орон тоо батлах тухай тушаалын төслийг боловсруулж, Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/133 тушаалын 1 дүгээр хавсралтаар Хөгжлийн бэрхшээлтэй	

						хүний хөгжлийн төвийн зохион байгуулалтын бүтэц, 2 хавсралтаар төвийн дүрмийг батлуулсан.	
3.8	Арга хэмжээ 7.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, түүний харьяа байгууллагуудын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлуулах	-	Хэрэгжилтийн хувь	-	100	ГБХНХ-ын сайдын 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/74 тоот тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг батлуулсан. ГБХНХ-ын сайдын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/87 тоот тушаалын хавсралтаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн бүтэц, орон тоог батлуулсан. Мөн ГБХНХ-ын сайдын 2024 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн А/80 тоот тушаалын хавсралтаар Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн бүтцийн орон тоог батлуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны "Төсвийн зарим байгууллагыг өөрчлөн зохион байгуулах, татан буулгах тухай" 55 дугаар тогтоолоор байгуулагдсан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа "Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв"-ийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын харьяа "Сэргээн засах, туслах үйлчилгээний үндэсний төв" болгож өөрчлөх "Төсвийн байгууллагыг өөрчлөн зохион байгуулах тухай"	100

						Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын гишүүдээс санал авахаар 01/1791 тоот албан бичгээр хүргүүлсэн. Саналыг нэгтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэхээр ажиллаж байна.	
3.9	Арга хэмжээ 7.9.Хууль тогтоомж, бодлогын баримт бичигт туссан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, тайлагнах	-	Хэрэгжилтийн хувь	100	100	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тайлан гаргах хуваарь батлах тухай” А/50 дугаар тушаал батлагдсан хуваарийн дагуу хууль тогтоомж, бодлогын баримт бичигт туссан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, хугацаанд нь тайлагнан ажилласан.	100
3.10	Арга хэмжээ 7.8.Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлт, албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг хүргүүлэх;	-	Шийдвэрлэлтийн хувь	100	100	Албан хэрэг хөтлөлтийн erp.mls.gov.mn цахим системээр ирүүлсэн хариутай 58 албан бичиг, хариугүй 116 албан бичиг, нийт 174 албан бичиг ирсэн бөгөөд хяналтанд байгаа 2, хугацаа хэтэрсэн 3, шийдвэрлэлтийн хувь 91,4 хувьтай байна. Мөн иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн 48 өргөдлийг хүлээн авч, хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж, хариуг хүргүүлж ажилласан. Тус хэлтсийн албан хаагчид тайлант хугацаанд 138 албан бичгийг боловсруулж, холбогдох газарт хүргүүлсэн байна.	91,4

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
С.РЭГЗЭНГИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
Нэгжийн нэр: Гэр бүлийн бодлогын газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	87,3	61,1

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэлх оноогоор)
1.	Арга хэмжээ 1. МУИС-ын Нийгмийн ухааны сургуулийн Антрапологи, архелогийн тэнхимд Хүн ам зүйн докторантурт суралцаж байна. Сургалтын төлөвлөгөөний дагуу судалгаа хийх чиглэлээ тогтоосон. Энэ хүрээнд "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх ур чадварыг үнэлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх нь" сэдвээр диссертация бичих бөгөөд судалгааны төлөвлөгөөгөө удирдагч багштайгаа хамтран боловсруулж, батлуулахаар бэлтгэж байна	100%	15
2.	Арга хэмжээ 2. Мандах их сургуулиас зохион байгуулсан "Бизнесийн удирдлагын цогц мэдлэг олгох сургалт"-д 4 сарын 19-өөс 5 сарын 31-ний хооронд цахимаар оролцож, сертификат авсан	100%	15
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			15

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	7
2.	Удирдан зохион байгуулах	7
3.	Асуудал шийдвэрлэх	7
4.	Манлайлах	7

5.	Багаар ажиллах	7
6.	Харилцаа	7
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7.	Мэргэжлийн ур чадвар 1.	
8.	Мэргэжлийн ур чадвар 2.	
9.	Мэргэжлийн ур чадвар 3.	
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		7

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)	61,1
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		91,1

Үнэлгээ өгсөн:

Газрын дарга

Гэр бүлийн бодлогын газрын дарга



(Ц.Мөнхзул)

2025.06.13
(огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Нэгжийн дарга:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний
хөгжлийн хэлтсийн дарга



(С.Рэгзэн)

2025.06.13
(огноо)